



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/69

Ховд

Бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "А" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь заалт, Төрийн албаны тухай хууль, Төрийн Албаны Зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 31 –ний өдрийн А/873 дугаар захирамжийг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны орон тоо бүтцийг хавсралтаар баталсугай.

2. Худалдан авах ажиллагааны албаны албан хаагчдын ажил үүргийн хуваарь, хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлж, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчилэн боловсруулж, Төрийн албаны салбар зөвлөлөөр хянуулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
02 дугаар сарын 08-ны өдрийн А/69  
дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ БҮТЭЦ ОРОН ТОО

Д/Д	Бүтэц	Тоо
1	Худалдан авах ажиллагааны албаны дарга	1
2	Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, сум хариуцсан мэргэжилтэн	1
4	Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн /Бичиг хэрэг/	1
5	Худалдан авах ажиллагааны сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн /нягтлан бодогч/	1
6	Нийт	5

-oOo-